

АХБ-ны МОНГОЛ ДАХЬ ЦАХИМ ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ТӨСӨЛ

ТА6618

ТАЙЛАНГИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ХУРААНГУЙ

2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр

Дэлхий нийтээрээ урьд нь мэддэг байсан ч дотоод, гадаадад илүү үр дүнтэй, ашигтай худалдаа хийх арга зам нь цахим харилцаа юм гэдгийг Ковид-19-ийн цар тахлын үе дахин нотоллоо. Гэхдээ ийм харилцаа холбоог ашигладаг бизнесийн шинэлэг аргууд нь ихэвчлэн цаасан, эсвэл хэвлэмэл харилцаанд зориулагдсан эрх зүйн орчинтой. Энэ нь тодорхойгүй байдал үүсгэж үр ашигтай гүйлгээнд саад учруулах талтай. Сүүлийн 25 жилийн хугацаанд цахим гүйлгээг дэмжсэн эрх зүйн орчныг дэлхий нийтээр бүрдүүлж байна.

Энэхүү тайланд Монгол дахь цахим худалдааны эрх зүйн орчны талаар судалж, хууль тогтоомж, тушаал шийдвэр нь цахим худалдааг дэмжих улс орны зорилгод нийцэж байгаа эсэхийг авч үзлээ.

Цахим гүйлгээ

Цахим худалдааны үндсэн үйл ажиллагаа нь голцуу нэг талаас нөгөө талдаа юм худалдах зорилготой арилжааны гүйлгээ юм. Арилжааг зохицуулсан хуулиуд нь ихэнхдээ "ялгаварлахгүй байх" зарчимтай, энэ нь цаасан, бодит болон онлайн гүйлгээнд адилхан үйлчилдэг гэсэн үг. Энэ асуудлаар цөөн хэдэн газарт л хуулийг өөрчлөх шаардлагатай байна. Монгол Улс хуулийн шинэчлэлийн хүрээнд Иргэний хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, мөн хувийн нууц, цахим аюулгүй байдлын асуудлыг зохицуулсан хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Иргэний хуульд хуулиар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлэх, бодитоор баталгаажуулах шаардлагатай гэж заасан хэлцлийг Цахим гарын үсгийн тухай хуулийн хүрээнд цахим гарын үсгийг хавсаргасан тохиолдолд цахим хэлбэрээр хийж болно гэж заасан (нотариатын баримт бичгийг цахимаар гэрчлүүлэхийг тусад нь хуулиар заасан.)

Цахим гарын үсэг

Цахим гарын үсгийн тухай хуульд “цахим” болон “тоон” гарын үсгийг хоёуланг нь тодорхойлсон. Цахим гарын үсэг гэж цахим мэдээлэлд гарын үсэг зурсан, цахим тамга хэрэглэсэн этгээдийг тодорхойлох зорилгоор мэдээлэлд хавсаргасан, эсхүл нэгтгэсэн цахим өгөгдлийг гэж тодорхойлжээ. Харин “тоон гарын үсгийн хувийн түлхүүр /цаашид "хувийн түлхүүр" гэх/ ашиглан мэдээллийг шифрлэж хувиргалтад оруулж үүсгэсэн” өгөгдлийг тоон гарын үсэг гэжээ. Тоон гарын үсгээр гарын үсэг зурсан этгээд (хувийн түлхүүр эзэмшигч)-ийг танихаас гадна гарын үсэг зурсны дараа мэдээлэл өөрчлөгдсөн, дутуу байгаа эсэхийг баталгаажуулах, мэдэх боломжтой.

Тоон гарын үсэгт тухайн өгөгдлийг хэн хянадгийг заасан гэрчилгээ дагалдана, үүнийг гэрчилгээжүүлэлтийн байгууллагаас олгоно. Хууль нь гэрчилгээжүүлэлтийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах дүрэм, бусад холбогдох үйлдлүүд (эдгээрийг хамтад нь "итгэлцлийн үйлчилгээ" гэж ойлгодог)-ийг заасан, эдгээр нь бүхэлдээ “нийтийн түлхүүрийн дэд бүтэц”-ийг бүрдүүлдэг бөгөөд “РКИ” гэдэг.

Цахим гарын үсгийн тухай хуульд тоон гарын үсэг нь гараар зурсан гарын үсэгтэй адил эрх зүйн чадамжтай гэжээ.

Уг хуульд тоон гарын үсгийг ашиглах талаар хэд хэдэн уян хатан заалттай, тоон гарын үсгийн тогтолцоог бий болгох талаар хэд хэдэн журам, зохицуулалтыг мөн заажээ. Эдгээр заалтууд хараахан хүчин төгөлдөр болоогүй бөгөөд журам нь хэрэгжиж эхлээгүй байна. Тиймээс тоон гарын үсгийг хувийн гүйлгээнд өргөнөөр ашиглаагүй байна. Тоон гарын үсгийг иргэд болон төрийн байгууллагуудын хооронд илүү түгээмэл ашигладаг, учир нь иргэний үнэмлэх дээр нь тоон гарын үсгийн мэдээллийг оруулсан байдаг.

Мэдээж хувийн гүйлгээг цахим хэлбэрээр хийж байна. Ялангуяа дотоодын болон олон улсын худалдааны платформ дээр бүтээгдэхүүнийг худалдан авч, борлуулж байна. Ийм гүйлгээнд хэрэглэж буй гарын үсгийн төрлийг хуулиар хэрхэн ялгасан нь тэр бүр тодорхойгүй.

Одоогоор цахим гарын үсгийг гэхээсээ илүү тоон гарын үсэг ашиглахыг дэмжсэн тодорхой заалт байхгүй, гэхдээ цахим гарын үсгийн тухай бусад хуулиудад зааж тусгасан байна.

Монголын цахим гарын үсгийн горимд илүү тууштай, илүү тодорхой дүн шинжилгээ хийх хэрэгтэй байж болох юм, ингэснээр цахим гарын үсгийг илүү найдвартай, аюулгүй болгохоос гадна хувийн талуудад хэр зэрэг аюулгүй байхыг хүсч байгаагаа өөрсдөө шийдэх сонголт өгөх нь зүйтэй. Нийтийн ашиг сонирхол нь бүх талууд, бүх хэлцлийн хувьд ижил хамааралтай биш.

Тус тайланд Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын Цахим харилцааны конвенцийг дотоодын хуультай адил байдлаар хэрэгжүүлэхийг зөвлөсөн. Ийнхүү хэрэгжүүлсний үр дагаврын талаар тайлангийн хавсралтад тайлбарласан болно. Зарим нэмэлт заалтуудыг оруулах талаар тайлангийн бусад хэсэгт мөн авч үзсэн.

Худалдааны платформ

Монголд интернетээр дамжуулан бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын программ хангамж, техникийг сайтар бүрдүүлсэн “худалдааны платформ”-оор дамжуулан ихээхэн гүйлгээ хийж байна. Худалдааны платформ нь бараа бүтээгдэхүүнээ зах зээлд гаргах гарцыг санал болгож, интернет орчинд шууд ажиллах цаг, чадвар, тоног төхөөрөмж байхгүй худалдагчид өргөн боломжийг олгодог.

Худалдааны платформыг ашиглах нь гүйлгээг хэрхэн хүчинтэй гэж үзэх, хэрэглэгчийн болон хувийн нууцыг зохих ёсоор хамгаалах, хэрэглэгчид болон ялангуяа худалдаачид хоорондоо болон платформтой зүй бусаар өрсөлдөхгүй шударга харьцах зэрэг эрх зүйн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг тухайн харилцааг зохицуулсан зохих хуулиудад тусгах, эсвэл платформын ажиллагаанд чиглэсэн цахим худалдааны хууль болгон нэгтгэн зохицуулж болно.

Цахим худалдааны тухай хууль: бусад харилцаа

Цахим баримт бичиг, цахим гарын үсэг, худалдааны платформуос гадна олон улсын шилдэг туршлагаас авч цахим худалдааны тухай ерөнхий хуульд тусгаж болох бусад заалтуудыг энэ тайланд санал болгосон. Эдгээрийн дотор мэдээлэл нь зөвхөн цахим хэлбэрээр байгаа учраас хууль ёсны хүчин төгөлдөр гэж үзэхээс татгалзаж болохгүй гэсэн ерөнхий “ялгаварлан гадуурхахгүй” гэсэн зарчим байна. Цаашлаад цахим мэдээллийг хэзээ

илгээсэн, хүлээн авсан гэж үзэх, цаг хугацаа, нөгөө талын хүн байхгүй ч гэсэн цахимаар гэрээ байгуулах эрх (жишээ нь, цахимаар борлуулалт хийх), онлайн захиалгынг буруу хийсэн, алдаа гаргасан бол засах ажиллагаа зэрэг бусад асуудал бас бий.

Төрийн болон хувийн хэвшлийн оролцогч талууд зөвшилцсөний үндсэн дээр албан ёсны борлуулагч болон сошиал орчинд борлуулдаг этгээдийн хооронд зөв зохицуулалт хийж, шударга татварын бодлоготой байх санал гаргасан.

Цахим худалдаа практикт

Цахим орчинд бизнес эрхлэхэд гарч буй саад бэрхшээлүүд нь хууль тогтоомжуудаас илүүтэй соёлын болон технологийн саад бэрхшээлээс шалтгаалдаг болох нь батлагдсан.

Соёлын талаас нь авч үзсэн, зарим худалдан авагчид цахим гарын үсэг хуулиар зөвшөөрсөн ч гэлээ зөвхөн цаасан дээрх бэхээр бичсэн гарын үсэгт итгэх хандлагатай байдаг. Зарим талаар, бизнес эрхлэгчид Цахим гарын үсгийн тухай хууль болон бусад холбоотой шинэ хууль тогтоомжууд өөрт нь нийцэх эсэхийг харзнаж байж болох юм.

2022 оны 6 сард зохион байгуулсан хэлэлцүүлгээр Монголд цахим худалдаа эрхлэхэд бэрхшээл үүсгэж буй зарим хүчин зүйлсийг дараах байдлаар дурдсан:

- Хилийн асуудал: Бараа бүтээгдэхүүн импортлох болон экспортлоход хил хаагдах, удаашрах асуудал үүсдэг.
- Хүргэлтийн үйлчилгээ ялангуяа алслагдсан бүсүүдэд төвөгтэй бөгөөд өндөр зардалтай.
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт итгэдэггүй
- Мэдээллийн аюулгүй байдалд анхаарал хандуулах шаардлагатай
- Цахим төлбөрийн хэрэгслүүд дээр хяналт тавих шаардлагатай
- Залилан мэхлэх, хуурамч вэбсайтууд олон бөгөөд найдвартай системүүд нь өртөг өндөр
- Утасны СИМ картад суурилсан цахим гарын үсэг нь иргэний үнэмлэх дээр суурилуулсан гарын үсэг ашиглахаас илүү хялбар. Монголд СИМ картад суурилсан цахим гэрчилгээ олгодог газрууд байдаг.
- Иргэдэд цахим худалдааг сурталчлан, таниулах нь үйлчилгээг илүү хялбаршуулж өгнө.
- Хамтын ажиллагаа нь худалдаа эрхлэгч, худалдан авагч болон хууль тогтоох шатныханд эдийн засаг болон практик ач холбогдолтой байх болно.

Монгол Улсын Засгийн газар “e-Mongolia” хөтөлбөрийн хүрээнд, ихэвчлэн цахим гарын үсгээр баталгааждаг цахим үйлчилгээнүүдийг олон нийтэд үзүүлдэг бөгөөд энэ нь бүх шатны төрийн байгууллагаас үзүүлж буй 2,000 орчим үйлчилгээг багтаасан. Ийм хөтөлбөр нь Монголчуудыг цахим харилцаа холбоонд итгэх итгэлийг нэмэгдүүлж цахим орчинд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд дадуулж байна.

Хил дамнасан худалдаа

Хил дамнасан цахим худалдааг үр дүнтэй байлгах гол түлхүүр нь шаардлагатай бүх баримт бичгүүд шийдвэр гаргах байгууллагад хүргэгдэж, тэндээсээ зөвшөөрлөө авч болох “нэг-цонхны” үйлчилгээ юм. Ийм үйлчилгээ Монголд шаардлагатай гэдгийг олон жилийн өмнө мэдсэн ч 2025 он хүртэл ийм цонх ашиглалтад орохооргүй байна.

Энэхүү тайланд цахим худалдааны бүрэлдэхүүн хэсэг, ялангуяа хил дамнасан худалдааны талаар авч үзсэн болно. Үүнд Монголд гаалийн татвараас чөлөөлөх *de minimis* босго тогтоох арга, мөн биет бус хөрөнгийн худалдаанд тулгарч буй бэрхшээлийн талаар товч хэлэлцэв.

Монголын гаалийн байгууллага нь гаалийн цахим үйлчилгээний системээрээ дамжуулан цахимаар харилцах чадавх, бололцоогоо тогтмол нэмэгдүүлж байна. Үүнийг хамгийн үр дүнтэй болгохын тулд хөрш орнууд болон худалдааны гол түншүүдтэй цаашид зөвлөлдөх шаардлагатай. Бараа, үйлчилгээний гарал үүслийн цахим гэрчилгээтэй байх нь худалдаа эрхлэгчдэд нэн тустай байх юм.

Олон улсын эрх зүйн орчин

Олон улсын худалдааны хуулийн цар хүрээ нь цахим худалдаанд чухал байр суурьтай. Энэ нь дотоодын хууль тогтоомж хангалтгүй байгаа бол (Монголын хууль нь дотооддоо хүчин төгөлдөр сайн хэрэгждэг ч гэлээ), эсвэл талуудын эрх зүйн тэгш байдлыг хангахад тусална. Ийнхүү зохицуулах шаардлага хэзээд гарч ирдэг.

Монгол улс ДХБ-ын Худалдааг дэмжих хэлэлцээрт гишүүнээр элссэн бөгөөд энэ нь олон давуу талуудыг бий болгосны үр дүнд Япон улстай цахим худалдааг дэмжих заалттай чөлөөт худалдааны гэрээг байгуулсан явдал юм. CAREC (Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр) нь цахим худалдааг хөгжүүлэхээр ажиллаж байгаа.

Хэд хэдэн олон улсын хэлэлцээр нь дотоодын болон хил дамнасан цахим худалдааны хуульд шууд нөлөөлдөг. НҮБ-ын Цахим худалдааны конвенц нь Монголд саяхан хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн нь үүний нэг жишээ юм. Өмнө дурдсан НҮБ-ын АНБЭЗНБ-ын ерөнхий гэрээ нь тухайн зохицуулалтын хүрээнд зорилгууд тавьж, түүндээ хүрч ажиллахад түлхэц болдог.

Эцэст нь, зарим стандарт, удирдамжууд нь олон улсын түвшинд хэрэгжих боломжтой учраас тухайн орны туршлагыг олон улсынхтай нийцүүлэхэд тустай.

Зохицуулах харилцаа

Дотоодын болон олон улсын цахим худалдааны хууль, эрх зүйн саад бэрхшээлийг арилгахаас гадна, хил дамнасан эрх зүйн дүрэм журмуудыг хооронд нь уялдуулахын тулд цахим эрин зуунд худалдааны хэд хэдэн үйл ажиллагаанд зохицуулалт хийх шаардлагатай.

Хуулийн зохицуулалт нь цахим худалдааг дэмжих зөвхөн нэг хүчин зүйл нь юм гэдгийг тайланд тэмдэглэсэн. Эдийн засгийн үйл ажиллагаа, холбогдох техник технологийн дэд бүтэцгүйгээр дан ганц хууль тогтоомж нь цахим худалдааг явуулахгүй. Мөн хууль, эрх зүйн орчноос урьтаж хүмүүс цахим гүйлгээ хийх болон технологид итгэдэг соёл бүрэлдэх учиртай.

Тайланд хэлэлцсэн зарим зохицуулалт нь хүмүүсийн цахим орчны зохих хамгаалалт, хувийн мэдээллээ нууцлах, цахим гэмт хэргээс сэргийлэх зэрэг итгэлийг үүсгэх зорилготой

ч байж болно. Иймэрхүү зохицуулалт нь түүнийг хэрэгжүүлэх төсөв, нөөцийг төрөөс гаргаж чадах эсэхээс ихээхэн хамаардаг.

Цахим худалдааны бизнес гэдгийг тодорхойлох нь энэ төрлийн бизнесийг эхлүүлэхэд эрх зүйн талаас хөшүүрэг болж өгнө. Татварын хөнгөлөлт, татвар багаар тогтоох зэрэг чухал жишээнүүд бий. Тус тайлангаар бизнесийн хэмжээ, тогтвортой байдал зэргээс хамаарч ямар ямар хөнгөлөлтийг ямар шалгуураар хэн олгож болох талаар хэд хэдэн шалгууруудыг тогтоосон.

Ихэнх орнууд цахим худалдааг бусад бизнесээс эрх зүйн хүрээнд ялгаж салгадаггүй учраас цахим худалдааг бусад төрлийн худалдаанаас ангид зохицуулах агентлаг гэж байдаггүй. Гэхдээ цахим худалдаа нь тусдаа, бие даасан асуудал (хувийн мэдээлэл алдах г.м) үүсгэдэг бүс нутагт мэргэшсэн зохицуулагчид ажиллаж болно.

Худалдааны платформуудыг хуулиар зохицуулахад нэг хуулиар олон өөр асуудлыг (хэрэглэгчийг хамгаалах, хувийн мэдээлэл алдагдах г.м) зохицуулах нь илүү хялбар. Ингэснээр бизнес эрхлэгчид болон хэрэглэгчид худалдааны платформ нь ямар давуу болон эрсдэлтэй талуудтайг өөрсдөө үнэлэн шийдэх боломжийг олгож, хуулийн зохицуулалтыг хялбаршуулж өгнө. Гэхдээ Хятад, Вьетнам болон Европын холбооны орнууд болон бусад орнуудад илүү өргөн цар хүрээтэй зохицуулалттай.

Монгол улс **Хэрэглэгчийг хамгаалах** хууль эрх зүйн зохицуулалттай бөгөөд олон улсын стандартад нийцсэн шинэчилсэн найруулгыг боловсруулж байна. Тус хуулийн төслийн зайнаас болон цахим орчинд үйл ажиллагаа явуулах тухай бүлэг нь цахим худалдааны асуудлыг зохицуулна. Мөн энэ хуулийн төсөлд хэрэглэгчийг бүрэн, үнэн зөв мэдээллээр хангах, элдэв алдаа дутагдлыг засан сайжруулах талаар заалтуудыг багтаасан.

Хил дамнасан өгөгдлийн урсгал нь гэрээ хэлэлцээрт хамаарна, гэхдээ шилжүүлэн авч буй улс нь хүлээн авсан мэдээллийг дотоодын мэдээлэлтэй ижил төстэй хамгаалалтаар хамгаалах стандарт нөхцөл байдаг. Энэ тухай нэмэх хэрэгтэй.

Хувийн мэдээллийг дотооддоо хадгалах, “мэдээллийг нутагшуулах” тухай Монголд яриа байдаг юм. Ийм дүрэм тогтоовол Монгол-Японы чөлөөт худалдааны хэлэлцээр зэрэг чөлөөт худалдааны гэрээтэй зөрчилдөхийг тайланд анхааруулсан буй.

Мэдээллийн хамгаалалт нь ерөнхийдөө хувийн гэхээсээ илүү арилжааны мэдээллийн нууцыг хамгаалах зорилготой. Одоогоор яг энэ сэдвээр бие даасан хууль тогтоомж бага байна. Энэхүү тайланд ийм хуулийн зохицуулалттай болохыг санал болгосон, ингэхдээ тус улсын худалдааны гол түншүүдийн сайн жишээг харгалзаж болно.

Алсын зайнаас нотариатаар баталгаажуулах нь цахим нотариатын дараагийн алхам байж болох юм. Олон улсын загвар, жишээ байдаг. Ийм загвар нь найдвартай онлайн баталгаажуулах хэрэгсэл, бодит цагаар харуулсан видео холбоос зэрэгт үндэслэдэг, мөн нотариатаар гэрчлүүлсний дараа баримт бичгийн найдвартай менежментийг хангах.

Цахим гэмт хэрэг бол орчин үеийн интернет харилцааны онцлог юм. Монгол Улс нь компьютерт зөвшөөрөлгүй нэвтрэх, хортой программ тараахыг хориглох зэрэг стандарт заалттай. Хуурамч мэдээлэл өгөх, залилан мэхлэх, хуурамчаар үйлдэх, хулгайлах гэмт хэргийн эсрэг ердийн шийтгэл нь бодит болон цахим орчинд нэгэн адил үйлчилнэ. Цахим гэмт хэрэг хил дамнасан шинж чанартай байдаг тул хэрэг бүртгэлтийн ажиллагаа, шийдвэрлэх нь хүндрэлтэй байж болох бөгөөд энэ чиглэлээр хөрш улсууд болон олон

улсын байгууллагуудтай хамтран ажиллах нь чухал. Кибер аюулгүй байдлын тухай шинэ хууль нь ийм хамтын ажиллагааг илүү амар болгоно.

Цахим төлбөр тооцоог Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулдаг, үүгээр арилжааны банкуудын төлбөрийн системийг зохицуулах эрхийг Монголбанкинд олгосон. Тус улсын бүх цахим үнийн дүнг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэх ёстой.

Гадаадаас орж ирж буй төлбөр тооцооны асуудал нь монголчуудын цахим экспортод саад болж болох талтай байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх нь экспортлогчдын үр ашгийг дээшлүүлэхэд түлхэц болно.

Одоогийн байдлаар цахим төлбөрийн бэрхшээл нь хууль эрх зүйн гэхээсээ илүү техникийн шинжтэй мэт санагдаж байна.

Маргааныг шийдвэрлэх нь худалдааны чухал хэсэг юм учир нь алдаатай хүргэлт, эсвэл төлбөрөө төлөөгүй асуудлыг албан ёсоор шийдвэрлэх боломжтойг харуулж байгаа тул. Шүүх ажиллагаа нь үнэтэй бөгөөд ойлгоход хэцүү байдаг тул маргааныг шийдвэрлэх өөр аргууд нь ихэвчлэн тустай. Эвлэрүүлэн зуучлал, арбитр хоёр нь Монголд бий. Эдгээр нь ялангуяа эсрэг талын шүүхэд найдах албагүй хил дамнасан маргаанд ач холбогдолтой.

Монгол Улс энэ чиглэлээр олон улсын үндсэн баримт бичигт нэгдэн орсон, гэхдээ цаашдаа Эвлэрүүлэн зуучлалын үр дүнд бий болсон Олон улсын төлбөр тооцооны гэрээний тухай UNCITRAL-ийн загвар хуулийг хэрэгжүүлэх талаар авч үзэх нь зүйтэй.

Маргааныг онлайнаар шийдвэрлэх (ODR) систем нь нь дэлхийн зарим хэсэгт ирээдүйтэй мэт ажиллаж байгаа ч өөрөө бие даан ажилладаг ийм тогтолцоог бий болгоход ер нь бол төвөгтэй. Монголд богино болон дунд хугацаанд ийм ODR-г хэрэгжүүлэхийг төлөвлөөгүй байна.

Иргэний хариуцлага нь сайн зан үйлийг төлөвшүүлэх, хайхрамжгүй байдлаас үүдэлтэй хохирлыг арилгах хүчин зүйл болдог. Энэ харилцаанд зуучлагчийн хариуцлага бол гол бүрэлдэхүүн нь юм. Цахим худалдаанд оролцогчид интернетийн үйлчилгээ үзүүлэгчээс эхлээд харилцаа холбооны компани, худалдааны платформ зэрэг хэд хэдэн зуучлагч байдаг. Хил дамнасан худалдааны хувьд гэвэл гаалийн байгууллага, “нэг цонх”-ны үйлчилгээ бас байж болно.

Ийм зуучлагчдаас хайхрамжгүй байдлаасаа болж бусдад учруулсан хохирлынхоо төлөө бүрэн хариуцлага хүлээхийг шаардахгүй байх бодлого байж болно. Тэдгээр нь төрийн байгууллага байж болно, эсвэл систем нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, төлбөрийн чадвартай байхын тулд зэрэг шалтгаанаар ийм шаардлага тавьдаггүй байж болно. Төсвөөс санхүүждэг байгууллагуудыг мөнгөтэй холбоотой шийдвэрийг заавал биелүүлэхээс хамгаалж хязгаарласан олон улс орон бий. Зуучлагч нь гүйлгээний агуулгыг өөрчлөөгүй дамжуулсан, хадгалсан бол цахим мессеж, бараа, үйлчилгээний агуулгын төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй гэсэн зарчим бусад орнуудад түгээмэл юм. Хуульд нэмэлт өөрчлөлт хийх бол үүнтэй холбоотой Манилагийн зарчмуудыг анхаарч үзэх хэрэгтэй.

Эдгээр заалтууд нь дэлхийн хэмжээнд зуучлагчийн хариуцлагын тогтоосон үндсэн зарчим юм. Худалдаа хийхээс өмнө хариуцлагыг хязгаарласан заалтыг харуулдаг байх нь чухал. Ингэснээр худалдагч этгээд өөрийн эрсдэлээ үнэлж даатгал хэрэгтэй эсэхээ бодох боломжтой.

Хуулийн шинэчлэлийн талаар ерөнхийд нь дүгнэхэд, хувийн үйл ажиллагааг төрөөс хэр зааж хянах вэ гэдэг асуулт нь худалдаанд оролцогч инновацийн үр шимийг хүртэхийн тулд хэр их эрсдэл тэсвэрлэх чадвартай вэ гэдгээс хамаарна: бизнесүүд дампуурахыг зөвшөөрдөг үү? Талууд өөрсдийгөө хамгаалж чадах уу, эсвэл төр хамгаалах ёстой юу?

Дүгнэлт

Олон улсын хэмжүүр нь арилжааны харилцааг улам бүр хөдөлгөж, улмаар хуулийн шинэчлэлийн тэргүүлэх чиглэлийг бий болгож байгаа тул тайлан нь дүгнэлтдээ хөрш орнууд болон худалдааны түншүүдтэйгээ хууль тогтоомж, стандартыг уялдуулахыг уриалж байна.

Дотоодын болон хил дамнасан цаасгүй худалдаа мэдэгдэхүйц өргөжихгүй байгаагийн шалтгаан нь хууль, зохицуулалтын дутагдал биш харин технологи, арилжааны соёл, байгаа боломжуудыг ашиглах санхүүгийн эх үүсвэрийн дутагдалтай илүүтэй холбоотой.

----oOo----